

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая

Юкататай салют



Японы зуны өнгө үзэмж гэхээр, хамгийн эхэнд санаанд орж ирдэг юм нь шөнийн тэнгэрт гялалзах үзэсгэлэнтэй салют байдаг. Юката эсвэл жинбэй өмсөн, салют буудуулахыг үзэхээр явах нь Японы зуны нэг зугаа юм. Юката өмсөх ёсны “миги-маэ/右前” гэдэг нь, эхлээд баруун гартаа барьсан талыг нь, дараа нь зүүн талыг нь гэсэн дараалалтайгаар өмсөхийг хэлнэ. Эсрэгээрээ, “хидари-маэ/左前” гэдэг нь, талийгаачид кимоно өмсгөхөд хэрэглэгддэг хэлбэр тул, ёр муутай гэж үздэг. Юката нь өмсөхөд харьцангуй хялбар тул, эдгээр ёсуудыг баримтлан, туршиж үзээрэй.


“とも/Томо” нь, Японд амьдрахад хэрэг болох мэдээлэл, Япон хэл сурахад хэрэг болох зүйлс зэргийг, дуудлагыг нь хадсан Япон хэл болон гадаадын 9 орны хэл (Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбодж, Мьянмар, Монгол, Англи) дээр гаргадаг.

(<https://www.jitco.or.jp/ja/tomo/>)





“Банкны данс”-тай холбоотой юунд анхаарах ёстой вэ?



Японд амьдрахад шаардлагатай банкны данс. Банкны данс нь, зөвхөн мөнгө байршуулан, хадгалах зориулалттай зүйл биш ба цалин авах, гадаад руу мөнгө шилжүүлэх зэрэг төрөл бүрийн мөнгөн гүйлгээнд ашиглагддаг. Банкны дэвтэр, бэлэн мөнгөний картаа гэж үрэгдүүлэхээс сайн болгоомжилж, ашиглахгүй үедээ аюулгүй газар хадгалаарай.

Дараах зүйлсийн аль нэг нь танд хамааралтай бол, та данс нээлгэсэн газар (банк г.м санхүүгийн байгууллага) руугаа холбоо барих шаардлагатай.


☒ Оршин суугаа хаяг, оршин суух хугацаа, визний статус өөрчлөгдсөн бол



☒ Ажлаасаа гарсан бол




☒ Банкны дэвтэр эсвэл бэлэн мөнгөний картаа гэж үрэгдүүлсэн бол



☒ Нутаг буцах бол



Зарим санхүүгийн байгууллагууд визний хугацаа нь дууссан данснаас мөнгө гаргаж авах, шилжүүлэх үйлдэл хийх боломжгүй болсон. Энэ нь, хууль бусаар авч өгөлцсөн дансыг тусгай залилан г.м гэмт хэрэгт ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм. Тиймээс хэрвээ визний статус өөрчлөгдсөн г.м шалтгаанаар Японд оршин суух хугацаагаа сунгах бол, санхүүгийн байгууллагад заавал мэдэгдэл гаргаарай. Мэдэгдэл гаргаагүй тохиолдолд, зүй ёсны оршин суух статустай эсэхийг баталгаажуулах хүртэл, өөрийн данс байлаа ч, мөнгө гаргаж авах боломжгүй болох тохиолдол байдаг тул, сайн анхаараарай.



Дараах үйлдлүүд нь гэмт хэрэг болно!



Банкны дэвтэр, бэлэн мөнгөний картыг бусдад худалдах, бусдад өгөх, зээлдүүлэх нь гэмт хэрэг юм. Интернет банкны нэвтрэх мэдээллээ бусдад өгч, дансаа бусдад ашиглуулах нь ч мөн гэмт хэрэг юм. Facebook гэх мэт олон нийтийн сүлжээний сайт (SNS)-аас “Таны дансыг өндөр үнээр худалдаж авна.” г.м мессеж ирсэн ч, хариу өгч болохгүй.

Бэлэн мөнгөний карт, дебит карт, кредит карт зэргийг хуурамчаар үйлдвэрлэхэд оролцож болохгүй. Хуурамчаар үйлдвэрлэгдсэн карт эзэмших, хуурамч карт ашиглах нь мөн гэмт хэрэг юм.

Шаардлагатай лиценз, бүртгэлгүйгээр олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг “газар доорх банк”-ыг ашиглаж болохгүй.

Гэмт хэрэгт холбоотой мөнгийг эзэмшигч этгээдийг мэдэгдэхгүй болгож, мөрдөн байцаалтаас бултах гэсэн оролдлого гаргаж (мөнгө угаах) буй сэжигтэй гүйлгээнд оролцож болохгүй.



Болгоомжтой байгаарай!

- Захиргааны газрын албан хаагчид, цагдаа, банкны ажилтан г.м хүмүүс хэзээ ч таны бэлэн мөнгөний картын дугаар, нууц дугаарыг асууна гэж байхгүй.
- Банкны дансаа бусдад өгөх г.м хууль бус үйлдэл хийвэл, Японд оршин суух, Япон руу нэвтрэн орох боломжгүй болох тохиолдол байдаг.

出典：金融庁 HP (<https://www.fsa.go.jp/user/livinginjapan.html>) を基に JITCO が作成

とも

2025年7月 夏季号

2025年7月1日発行

発行

電話
JITCO ホームページ

公益財団法人 国際人材協力機構 (JITCO)
総務部広報室
〒108-0023
東京都港区芝浦2-11-5
五十嵐ビルディング
03-4306-1166 (ダイヤルイン)
<https://www.jitco.or.jp/>



jitco.official



@jitco_official